



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 <sup>21</sup> он <sup>03</sup> дугаар  
сарын <sup>16</sup>-ны өдөр

Дугаар ХЭР/021

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА М.ОЮУНЧИМЭГ ТАНАА

Тайлан хүргүүлэх тухай

Таны 2021 оны УИХ-09/1779 тоот албан бичгийн дагуу Жендэрийн үндэсний хорооноос ирүүлсэн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайланг хүргүүлж байна.

Хүлээн авч танилцахыг хүсье.

Хавсралт 85 хуудас.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ

000021504093



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР  
ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРОО

Нэгдсэн үндэстний гудамж 20, Сүхбаатар дүүрэг  
6-р хороо, Улаанбаатар 14200-0063

Утас: 70071113, 70071117

Цахим шуудан: secretariat@gender.gov.mn

Цахим хуудас: www.gender.gov.mn

2021.03.12 № 3/40  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН  
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА Ц.НЯМДОРЖ ТАНАА

Тайлан хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны 2021 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн УИХ-09/1779 дугаартай албан бичгийн дагуу жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаарх Засгийн газрын тайлан болон Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний хураангуй тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Тус тайланг Монгол Улсын Их хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга М.Оюунчимэгт уламжилж өгөхийг Танаас хүсье.

Хавсралт 81 хуудастай.

Хүндэтгэсэн,

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА БӨГӨӨД  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА



Т.ЭНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

ЖЕНДЭРИЙН  
ҮНДЭСНИЙ ХОРОО

**ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ  
ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН  
2020 ОНЫ БАЙДЛААР**



## АГУУЛГА

<b>ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ</b> .....	<b>2</b>
Зорилт 1. Нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд жендэрийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүн тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх хүрээнд:.....	2
Зорилт 2. Жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсвийг үндэсний, салбарын, орон нутгийн байгууллагын түвшинд хэрэгжүүлэх хүрээнд: .....	6
Зорилт 3. Эрэгтэй, эмэгтэй хүний гэр бүл, нийгэмд гүйцэтгэх үүрэг, оролцооны талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн жендэрийн боловсролыг бүх нийтэд олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг өрнүүлэх хүрээнд:.....	9
Зорилт 4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний чадавхыг бэхжүүлэх хүрээнд:.....	13
Зорилт 5. Хүчирхийлэл болон ялгаварлан гадуурхалттай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд: .....	15
Зорилт 6. Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх хүрээнд:.....	17
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b> .....	<b>18</b>



## ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 129 дугаар тогтоолоор “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийг баталж, Хөдөлмөр, ниймгийн хамгааллын сайдын 2017 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн А/132 дугаар тушаалаар “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г баталсан.

Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулсан Жендэрийн үндэсний хороо, түүний Ажлын алба нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, биелэлтэд нь хяналт тавих ажлыг зохион байгуулах, энэ чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн зүгээс гаргасан үүсгэл санаачилгыг дэмжих, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэгтэй ажиллаж байна.

Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлэх, жендэрийн эрх тэгш байдлын талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн цогц арга хэмжээгээр хуулийн хэрэгжилтийг хангах, улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн харилцаанд жендэрийн тэгш байдлыг хангах зорилгоор тус хөтөлбөрийг 2017-2021 онд хэрэгжүүлэх бөгөөд 6 зорилтын хүрээнд хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

**Зорилт 1. Нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд жендэрийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүн тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх хүрээнд:**

1.1.Хөдөлмөрийн мөлжлөг, ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг үл тэвчих орчныг бүрдүүлэх асуудлыг төр, хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжийн хөдөлмөрийн дотоод журамд тусгуулан хэрэгжилтийг үнэлэх үзүүлэлтийг тодорхойлж нэвтрүүлэх.

Жендэрийн үндэсний хорооноос “Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй холбоотой гомдлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хүрээнд хянан шийдвэрлэх талаарх арга зүйн зөвлөмж”-ийг төрийн байгууллага болон хувийн хэвшлийн байгууллагад зориулан тус тус боловсруулж холбогдох 109 байгууллагад хүргүүлэв.

Албан ёсны статистикийг бүрдүүлэх хүрээнд ҮСХ-оос баталсан жендэрийн тэгш байдлыг хангах талаар авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлангийн захиргааны маягтад ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй холбоотой гомдлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусгасан байгууллагын тоог хүлээн авч нэгтгэдэг боллоо. Төрийн захиргааны төв байгууллагаас 10, харьяа агентлагаас 23, нийслэлээс 43, орон нутгаас 385 нийт 461 байгууллага Хөдөлмөрийн дотоод журамдаа АББД болон ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх талаар тусгасан байна.

ХНХЯ нь Хөдөлмөрийн мөлжлөг ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг үл тэвчих орчныг бүрдүүлэх асуудлыг төр, хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжийн хөдөлмөрийн дотоод журамд тусгуулах асуудлыг Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгаад байна.



1.2.Иргэнийг ажилд авахад хүйсээр ялгаварлахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хүлээлгэх хариуцлагыг чангатгах зохицуулалтыг хуульд тусгах.

Бэлгийн дарамт учруулах зөрчлийг Зөрчлийн тухай хуулийн 6.26 зүйлд тусгалаа. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг УИХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хорооны Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Энэ хүрээнд иргэнийг ажилд авахад хүйсээр ялгаварлахаас урьдчилан сэргийлж, таслан зогсоох, хүлээлгэх хариуцлагыг чангатгах талаар холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хэлэлцэж байна.

1.3.Ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгоход чиглэсэн бодлогыг үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтран боловсруулж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид мөрдүүлэх арга хэмжээ авах.

“Ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгоход чиглэсэн бодлого”-ыг МҮЭХ-той хамтран боловсруулсан бөгөөд тус бодлогыг батлах ажлыг Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн 3 талт үндэсний хорооны 2020-2022 оны төлөвлөгөөнд тусгав. ХНХЯ-аас тус бодлогыг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид мөрдүүлэх арга хэмжээ авах талаар Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгаад байна.

Хувийн хэвшлийн байгууллагад жендэрийн тэгш байдлыг хангах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх удирдамжийг боловсруулж, Энержи ресурс, Говь ХК, Сод эгшиг ХХК дээр турших ажлыг хийж гүйцэтгэн удирдамжийг аж ахуйн нэгжүүдэд нэвтрүүлэх ажлыг МҮХАҮТ, МҮЭХ той хамтран хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

1.4.Адил хөдөлмөр эрхэлж байгаа эмэгтэй, эрэгтэй ажилтанд адил хэмжээний хөлс олгох үнэлгээний аргачлал боловсруулах.

ХНХЯ-аас “Тэгш шан хөлс олгох тухай” ОУХБ-ын 100 дугаар конвенцийн зарчим, үзэл баримтлалыг үндэсний хууль тогтоомжид тусгах зорилгоор Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 50.1.1-д “Ижил үнэлэмжтэй ажил үүрэг гүйцэтгэж байгаа ажилтны цалин хөлсний хэмжээ адил байх” гэж тусгасан.

“Адил тэгш цалин хөлсний хүйсээс үл хамаарах ажлын байрны үнэлгээ”-ний алхам алхмаар гарын авлагыг ашиглан “Ажлын байрны үнэлгээ хийх, ажил мэргэжлийг бүлэглэх, зэрэглэх” аргачлалыг боловсруулан Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороогоор батлуулсан. Цаашид хүйсийн ялгаатай байдлаас үл хамааран тухайн ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилсан цалин хөлсний тогтолцоог бүрдүүлэх зорилгоор үр дүнд суурилсан цалин хөлсний хэлбэрийг нэвтрүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд эхний ээлжид эрүүл мэнд, боловсролын салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

1.5.Малчин, тариаланч өрхийн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих бодлого, арга хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллага, шийдвэр гаргагчид зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавих.

ХХАХҮЯ 2020 оноос “Улсын сайн малчин өрх” гэж шалгаруулж эхэлсэн нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс нийгэмдээ болон гэр бүл хувийн амьдралын хүрээнд эрх тэгш үнэлэгдэж, эрх мэдлийн хувьд тэгш болж үр шимийг нь тэгш хүртэх боломжтой болж байна.



ХХААХҮ-ийн салбарын жендэрийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд салбарын бүх тайлан мэдээнд хүнтэй холбоотой мэдээллийг хүйсээр харуулах чиглэлийг яамны харьяа газруудад өгсний дагуу 2019 оноос жижиг, дунд бизнес эрхлэгчдээс эмэгтэй бизнес эрхлэгчийн ирүүлсэн төсөл, олгосон зээлийн хэмжээ зэрэг мэдээллийг гаргах боломжтой болов. 2020 онд жижиг, дунд үйлдвэрлэгч 249 бизнес эрхлэгч төсөл ирүүлснээс 22,8 тэрбум төгрөг олгосон байна. Үүнээс 107 эмэгтэй бизнес эрхлэгч 9,7 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилт олгосон байна.

1.6.Эмэгтэй, эрэгтэй хүн болон нийгмийн бүлгийн хэрэгцээнд нийцсэн тэгш хүртээмж ногоон ажлын байр бий болгох үндэсний болон бусад улсын сайн туршлагыг судлах.

Төв аймгийн Борнуур сумын ойн санг гэрээгээр эзэмшдэг 4 нөхөрлөлийг сонгон “Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш оролцоог дэмжин ойн нөхөрлөлийг хөгжүүлэх” туршлагыг 2019 оноос эхлэн орон нутгийн онцлог, нөөцөд түшиглэн жишиг болгохоор 2 дахь жилдээ ажиллаж байна.

1.7.Ядуурлын эсрэг, тэгш оролцоот, хүртээмжит ногоон хөгжлийн хандлагыг нэвтрүүлэх гарын авлага боловсруулан түгээх.

2019 онд Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын хууль тогтоомж, тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн талаарх мэдлэг мэдээллийг олон нийтэд хүргэх, тогтвортой амьдралын хэв маягийг хэвшүүлэх чиглэлээр нийт 3500 ном гарын авлага боловсруулж, 250 гаруй төрийн байгууллага, ТББ, ЕБС, их сургуулиудад хүргэсэн.

Орон нутгийн бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн сургалтын хэрэгцээг тодорхойлох бичил судалгаа, түүнд суурилсан сургалтын гарын авлага боловсруулах, сургалт нөлөөллийн ажлуудыг төлөвлөн эхлүүлэв.

1.8.Олон хүүхэдтэй болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй, бага орлоготой, өрх толгойлсон эцэг (эх)-ийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн жендэрийн мэдрэмжтэй бодлогыг дэмжих.

“Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхэд тэтгэмж олгох тухай” хуулийн төслийг УИХ-ын 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэн баталсан. Энэ хуулиар Цалинтай ээж хөтөлбөр буюу 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эхчүүдэд сар бүр хүүхэд асарсаны тэтгэмжийг олгох эрх зүйн орчинг бүрдүүлж, 4 хүртэлх насны ихэр хүүхдэд нэг удаа, эхэд жирэмсэний 5 сартайгаас эхлэн төрөх хүртэл хугацаанд сар бүр тэтгэмж олгохоор хуульчилсан.

ЖДҮХС-аас Бизнес инкуботарын холбоо, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бизнес инкубаторын холбоотой хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд бичил зээл олгож байна.

ХХААХҮЯ санаачлан төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн баруун бүс дахь “Драгон” салбарт хөгжлийн бэрхшээлтэй иргэний үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн борлуулах борлуулалтын цэгийг нээлээ. Тус борлуулалтын цэгээр дамжуулан 32 хөгжлийн бэрхшээлтэй иргэний бараа бүтээгдэхүүн худалдаалагдаж байна.

1.9.Гэр бүл төлөвлөлтийн талаар боловсрол олгох нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх эмч, мэргэжилтний ур чадварыг сайжруулах, иргэдийн насны онцлогт тохирсон мэдээлэл, сурталчилгаа хийх.



Эрүүл мэндийн яам “Эмэгтэйчүүд, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд гэр бүл төлөвлөлтийн тусламж үйлчилгээнд 6981 зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийг хамруулан жирэмснээс сэргийлэх эм, хэрэгсэл тарааж, эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл сургалт сурталчилгаанд 27 сумын 59 байгууллага, аж ахуйн нэгж, 12900 орчим иргэнийг хамруулан, 9000 гаруй гарын авлага, материал тараан сурталчиллаа. Жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгслээр зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийг хангах зорилгоор 2020 онд улсын төсвөөс 1.8 тэрбум төгрөгний санхүүжилт гаргах төсөв тооцооллыг боловсруулж, санхүүжилтийг шийдэн Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд ЖХЭХ-ийн хүртээмж хангамжийг нэмэгдүүлсэн.

Гэр бүлд зөвлөгөө өгөх 22 төв ажиллаж байгаа бөгөөд нийт ажилтнуудын 72.7 хувь нь гэр бүл судлаач, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан ажиллаж байна. Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагааг сайжруулахад анхаарч, ГБХЗХГ Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулан үнэ төлбөргүй зөвлөгөө үйлчилгээ үзүүлж байна.

1.10.Эрэгтэйчүүдэд зориулсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тасаг, кабинетыг бүх аймаг, дүүргийн эрүүл мэндийн төвд ажиллуулж, хүний нөөц, техник, тоног төхөөрөмжөөр хангах.

Холбогдох нөлөөллийн ажлуудыг хийсний үр дүнд улсын хэмжээнд 35 эрэгтэйчүүдийн тасаг кабинет үйл ажиллагаагаа эрчимжүүлж, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийж эхэллээ.

2020 онд Цэргийн төв эмнэлгийн орон тоог батлахад эрэгтэйчүүдийн эмчийн орон тоог нэмж батлуулсан. Нийслэлийн Налайх дүүрэг, Архангай, Хөвсгөл, Өмнөговь, Орхон, Булган, Увс, Төв аймгуудын эрэгтэйчүүдийн кабинетын үйл ажиллагааг тогтвортой дэмжих хүрээнд нийт 205 сая төгрөгөөр тоног төхөөрөмжөөр хангаж, нийт 3669 хүнд үзлэгт хамруулж, 142 хүнд шаардлагатай мэс ажилбарыг хийсэн байна.

Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулах ажлын хэсгийг шинэчлэн байгуулах Эрүүл мэндийн сайдын А/169 дүгээр тушаалын дагуу хөтөлбөрийн төсөл боловсруулагдсан.

1.11.Улирлын шинжтэй ажил, хөдөлмөр эрхлэгч, гар аргаар ашигт малтмал олборлож байгаа иргэн, малчид болон нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийг эрсдэлээс хамгаалах үйл ажиллагаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийх.

Дараах аймгууд нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж, үзлэгт хамруулсан талаар тайлагнасан байна. Үүнд: Говь-алтай аймаг 1865, Хэнтий аймаг 2800, Увс аймаг 6500 хүнийг иргэдийн эрүүл мэндийг эрсдэлээс хамгаалах үзлэгийг хийсэн байна.

1.12.Эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд жендэрийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлэх чадавх олгох цуврал сургалт зохион байгуулах.

Эрүүл мэндийн яам нь “Эмэгтэйчүүд, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд гэр бүл төлөвлөлтийн тусламж үйлчилгээнд 6981 зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийг хамруулан жирэмснээс сэргийлэх эм, хэрэгсэл тарааж, эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл сургалт сурталчилгаанд 27 сумын 59



байгууллага, аж ахуйн нэгж, 12900 орчим иргэнийг хамруулан, 9000 гаруй гарын авлага, материал тараан сурталчиллаа.

Эрүүл мэндийн хичээл заах үндэсний сургагч багш бэлтгэх хүрээнд аймаг, нийслэл, дүүргийн 90 багшийг 5 хоногийн хугацаатай вакум сургалтад хамруулж, гэрчилгээ олголоо. Энэ хүрээнд “Эрүүл мэнд” хичээлийн агуулга, хөтөлбөрийг “Хувийн эрүүл ахуй-орчны эрүүл мэнд”, “Хооллолт-хөдөлгөөн”, “Сэтгэцийн эрүүл мэнд”, “Хорт зуршил”, “Бэлгийн болон НҮЭМ”, “Жендэр”, “Аюулгүй байдал-анхны тусламж” гэсэн 6 чиглэлээр боловсруулж, багш нарыг бэлтгэлээ.

1.13. Эрүүл мэнд, нөхөн үржихүй, ялангуяа бэлгийн боловсрол олгох хичээлийн агуулгыг насны болон жендэрийн хувьд өвөрмөц хэрэгцээт бүлгийн онцлогт тохируулан боловсруулж, ерөнхий боловсролын сургуульд албан сургалтаар, их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт сонгон судлах хичээлийн хөтөлбөрт оруулах. Эрүүл мэндийн сайд, БСШУС-ын сайдын 2018 оны хамтарсан тушаалаар сургууль, цэцэрлэгийн эмч, сэтгэл зүйчийн ажлын байрны тодорхойлолт, сургууль, цэцэрлэгийн эрүүл мэндийн кабинетэд байх эм, багаж хэрэгслийн жагсаалтыг батлуулж, холбогдох байгууллагуудад хүргүүллээ.

БСШУСЯ-ны сайдын А/494 дүгээр тушаалаар Сургуулийн өмнөх боловсролд эрүүл мэндийн боловсрол олгох хөтөлбөр, агуулга, зөвлөмж, хэрэглэгдэхүүнийг боловсруулсан байна.

БШУЯ, ЭМЯ хамтран Боловсролын хүрээлэн, АШУУИС, СУБИС, СЭМҮТ, НЭМҮТ, ерөнхий боловсролын сургууль /ЕБС/-ийн төлөөллийг оролцуулан сургалтын хөтөлбөр боловсруулсан. Ийнхүү “Бага боловсролын сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж”, “Суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж”-ийг боловсруулан хэвлэмэл гарын авлага болгон нийтийн хүртээл болгосон.

## **Зорилт 2. Жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсвийг үндэсний, салбарын, орон нутгийн байгууллагын түвшинд хэрэгжүүлэх хүрээнд:**

2.1. Жендэр статистикийг нэгтгэн боловсруулах, програм хангамжийг нэвтрүүлэх. ЖҮХ болон ҮСХ нь хүйсээр ангилсан албан ёсны статистик болон бусад мэдээллийг ил тод нээлттэй, хүртээмжтэй болгох зорилгоор Жендэрийн статистикийг нэгтгэн боловсруулах программ хангамжийг нэвтрүүлэхээр хамтран ажиллаж байна.

Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад ажиллагсдын хүйсийн тэнцвэртэй байдлын судалгаа авах маягтыг ТАЗ-ийн “Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөн, статистик мэдээллийн маягт”-тай нэгтгэн холбогдох өөрчлөлт оруулж ҮСХ-оор батлуулав.

“Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, үр дүнгийн тайлангийн захиргааны статистикийн мэдээний маягт, түүнийг нөхөх зааврыг” ҮСХ-ны даргын 2020 оны А/50 тоот тушаалаар батлууллаа.

2.2. Жендэрийн статистикийг бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаанд ашиглах аргачлал боловсруулж хуулиар үүрэг хүлээгчдэд хүргүүлэх. Жендэрийн статистикийн үзүүлэлтийн хүрээ болон тооцох аргачлалыг шинэчлэн боловсруулж, ҮСХ-ны даргын 2019 оны А/173 тоот тушаалаар баталсан.



Үзүүлэлтийн хүрээнд нийт 14 бүлгийн 241 үзүүлэлтийг хамруулсан ба 12 үзүүлэлт нь Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтийг тооцох үзүүлэлт байна. Эдгээр үзүүлэлтийн 129-ийг нь албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллээс тооцно. Тухайлбал 96 үзүүлэлтийг статистикийн судалгаанаас, 16 үзүүлэлтийг статистикийн тооллогын мэдээллээс тооцох боломжтой болсон.

ҮСХ-ны 1212.mn статистикийн мэдээллийн цахим хуудаснаас “Жендэр” хэсгийг ЖҮХ-ны цахим хуудас уруу холбож, монгол, англи хэл дээр жендэрийн статистик үзүүлэлтүүдийг хэрэглэгчдэд хүргэх нөхцлийг хангаж ажиллалаа.

2.3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг үндэсний хэмжээнд хэлэлцүүлэх, гарсан зөвлөмжийг бодлого, төлөвлөлтөд тусгах арга хэмжээ авах.

“Монгол Улсын жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ: 2005 оноос өнөөг хүртэлх ололт амжилт ба сорилт, сургамж” тайлан боловсруулж, салбар, орон нутгийн түвшинд төр, ТББ, ИНБ-уудад танилцуулах ажлыг 2019 онд зохион байгуулав. Дүн шинжилгээний энэхүү тайлан нь Монгол улсын сүүлийн 14 жилийн статистик тоо мэдээлэл дээр үндэслэн боловсруулагдсан бөгөөд ойрын 5-10 жилд хөгжлийн бодлого, төлөвлөлт, үнэлгээнд ашиглагдах суурь судалгаа болсон.

2.4. Нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авч байгаа эмэгтэй, эрэгтэй тэтгэвэр авагчдын дунд судалгаа хийж, тэтгэврийн зөрүүтэй байдлыг арилгах талаар санал боловсруулах.

ХНХЯ-аас Нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авч байгаа эмэгтэй, эрэгтэй тэтгэвэр авагчдын дунд судалгаа хийж, тэтгэврийн зөрүүтэй байдлыг арилгах талаар санал боловсруулж, холбогдох албан хаагчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, 2019 оны судалгааны эцсийн тайланг холбогдох талуудад хүргүүлж ажилласан.

2.5. Иргэдийн газар, үл хөдлөх хөрөнгийн өмчлөлийн байдалд жендэрийн судалгаа, дүн шинжилгээ хийж, үр дүнг бодлого, үйл ажиллагаанд тусгах чиглэлээр ажиллах. ХЗДХЯам нь Тогтвортой Хөгжлийн Зорилтын “Үзүүлэлт 5.а.2. Эмэгтэйчүүдийн газар өмчлөх, захиран зарцуулах тэгш эрхийг баталгаажуулсан хууль эрх зүйн орчин (мөн уламжлалт заншлын хэм хэмжээ нь) бүрдүүлсэн байдал”-ын үнэлгээний арга зүй, аргачлалд саналыг Үндэсний статистикийн хороонд хүргүүлж ажилласан байна.

2.6. Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгэм, соёл, эдийн засгийн идэвх болон оролцоо, тэднийг үнэлэх үнэлэмж, хандлага, гэр бүлийн хүрээнд тулгамдаж байгаа асуудалд суурь судалгаа хийх.

Хороо Монгол Улсын эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүтэй байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлс баримт бичгийн судалгаа болон Эрэгтэйчүүдийн эрүүл мэндээ хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлох түүвэр, чанарын судалгааг 2019 онд ҮСХороотой хамтран хийсэн. Энэхүү судалгаанд суурилсан богино хугацаанд авч хэрэгжүүлэх “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг (2020-2022)-г” Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 99 дүгээр захирамжаар батлуулж ажиллав.

2.7. Залуу малчин эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн нөхцөл байдалд жендэрийн судалгаа, дүн шинжилгээ хийж, үр дүнг үндэсний хэмжээнд хэлэлцүүлж, гарсан зөвлөмжийг бодлого, төлөвлөлтөд тусгуулах арга хэмжээ авах.



ХХАХҮЯ-аас Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 34 дүгээр тогтоолоор “Монгол малчин” үндэсний хөтөлбөрийг батлуулсан. Хөтөлбөрт “малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах аян өрнүүлж, тэдгээрийн мэдлэг, туршлага, чадавхыг сайжруулах, хөгжүүлэх, малчдын залуу халааг бэлтгэх; залуу малчид, гэрээт болон туслах малчдад зориулсан сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх, туршлага судлуулах; залуу малчид, гэрээт болон туслах малчдад зориулсан сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх, туршлага судлуулах; “Шинэ хөдөө”, “Залуу малчин”, “Сарлаг”, “Тэмээ” зэрэг тухайлсан төсөл, дэд хөтөлбөрийг орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлж, малчдын орлого, ашгийг нэмэгдүүлэх” заалтуудыг тусгуулсан байна.

Хорооноос малчдын нөхцөл байдалд жендэрийн судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг төлөвлөн эхлүүлээд байна.

2.8.Салбарын болон орон нутгийн бодлого, үйл ажиллагаанд оролцоонд суурилсан жендэрийн үнэлгээ хийж, гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх.

“Орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрт оролцооны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”, “Салбарын жендэрийн бодлогод оролцооны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ыг тус тус боловсруулж Жендэрийн салбар зөвлөл, хороод болон холбогдох байгууллагуудад хүргүүлэв. Тус аргачлалыг 21 аймгийн ЗДТГ, 107 ТББ, ИНБ-ийн төлөөлөлд танилцуулах, бүсийн сургалтуудыг зохион байгууллаа.

Орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрт оролцооны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тэтгэлэг зарлаж Баянхонгор, Булган, Ховд, Өмнөговь, Дорнод аймгуудын ИНБ-ын нэгдсэн багуудыг шалгаруулж, тус бүр 4000\$ нийт 20000\$ тэтгэлэгийг олгоод байна. Багуудын хийсэн үнэлгээний үр дүнд тулгуурлан орон нутгийн удирдлагуудад дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах талаарх зөвлөмжийг хүргүүлэн ажиллах юм.

2.9.Орон нутгийн хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар хороодоос сум, баг, хороотой хамтран ажиллах удирдамж гаргах.

Жендэрийн салбар хорооноос орон нутгийн хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг ханган ажиллах удирдамж, НЗБ-аас ЖЭТБХ үйл ажиллагааны үр дүнгийн тайлан, мэдээ, орон нутгийн хэмжээнд гаргаж болох жендэрийн статистик үзүүлэлт, Аймаг нийслэлийн ИТХ-ын төлөөлөгчдийн хүйсийн тэнцвэрт байдлын тайлан мэдээг хүлээн авах маягтын хамт жендэрийн 31 салбар хороо, 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн ИТХ-д хүргүүлсэн.

2.10.Бүх шатны Засаг даргын үр дүнгийн гэрээнд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар тусгах.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг тусгуулж ажиллах талаар бүх яамдын ТНБДаргаар ахлуулсан жендэрийн салбар зөвлөлд 2021 оноос салбарын сайд орон нутгийн удирдлагуудтай байгуулдаг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг тусгуулж ажиллах талаар заавар, зөвлөмж өгч ажиллав.

Орон нутаг, нийслэлийн 207 Засаг даргын үр дүнгийн гэрээнд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар тусгасан байна.



2.11.Салбарын жендэрийн нэгдсэн бодлого, аймаг, нийслэл, дүүргийн жендэрийн дэд хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх.

ЖЭТБХ талаар “Орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөр боловсруулах удирдамж” болон Төрийн захиргааны байгууллагад зориулсан “Жендэрийн бодлогын баримт бичиг боловсруулах нэгдсэн удирдамж”-ийг боловсруулан талуудад хүргүүлэн ажилласны үр дүнд 21 аймаг, нийслэл, нийслэлийн 8 дүүрэгт жендэрийн дэд хөтөлбөр, 9 салбарт жендэрийн бодлого батлагдав.

2.12.Төрийн байгууллагын төсөв боловсруулах үүрэгтэй ажилтныг жендэрийн мэдрэмжтэй төсөв хийх цахим сургалтад хамруулах.

Хороо нь төрийн албан хаагчдад зориулсан “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого төлөвлөлт, төсөвлөлт” сургалтын гарын авлага боловсруулж, холбогдох талуудад хүргүүлэв. Орон нутаг, нийслэл, дүүргийн хэмжээнд 655 албан хаагчийг жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт сургалтад хамруулсан.

Сангийн яамнаас Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн сургалтын хөтөлбөрийн төслийг боловсруулж, холбогдох талуудаас санал авч, чадавч бэхжүүлэх сургалтыг бүх оролцогч талуудад 2021 онд хийхээр төлөвлөсөн байна.

2.13.Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд жендэрийн дүн шинжилгээ хийж, төсвийн жендэрийн мэдрэмжтэй төсөвлөх, үнэлэх аргачлал боловсруулах.

Төсөв санхүүгийн удирдлагын шинэчлэлийн стратегийн хүрээнд төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд жендэрийн дүн шинжилгээ хийх, жендэрийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлтийг салбарын яамдад үе шаттай туршин нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах Ажлын хэсгийг Сангийн яамны ТНБДаргын 2020 оны А/88 тушаалаар байгууллаа. Энэхүү ажлын хүрээнд БШУЯ, ХНХЯамыг сонгож туршилтыг эхлүүлэхээр бэлтгэлийг ханган ажиллаж байна.

Жендэрийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлтийг туршин нэвтрүүлэхээр Боловсрол, шинжлэх ухааны яам болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамыг сонгосон бөгөөд тус 2 яам дээр аргачлалыг салбарын төсвийн төлөвлөлтөд туршин нэвтрүүлэх үүрэг бүхий багийн бүрэлдэхүүнийг байгуулаад байна.

2.14.Гадаад улсын болон олон улсын байгууллагаас жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр манай улсад оруулсан хувь нэмэр, зарцуулсан санхүүжилтийн талаарх мэдээллийг нэгтгэн, зөвлөмж хүргүүлэх.

Жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр Хөгжлийн албан ёсны түншлэлийн хүрээнд хэрэгжсэн төсөл, хөтөлбөрүүдийн мэдээлэл, санхүүжилтэд судалгаа хийж, зөвлөмж боловсруулж, ГХЯ, ЖҮХ хамтран Монгол Улс дахь олон улсын хөгжлийн түншлэгч байгууллагууд болон холбогдох талуудад танилцуулах уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

**Зорилт 3. Эрэгтэй, эмэгтэй хүний гэр бүл, нийгэмд гүйцэтгэх үүрэг, оролцооны талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн жендэрийн боловсролыг бүх нийтэд олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг өрнүүлэх хүрээнд:**

3.1.Багш бэлтгэх сургууль болон багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт жендэрийн үнэлгээ хийж, жендэрийн асуудлыг тусгах.



Тус асуудлыг БШУЯ-ны Жендэрийн салбар зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган батлуулсан.

БШУЯам нь Дээд боловсролын шинэчлэлийн төсөлтэй хамтран Жендэрийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааны дүн шинжилгээ судалгааны тайлан, бодлогын зөвлөмж, удирдамж, сургалтын гарын авлагаыг төрийн болон хувийн өмчийн 5 их, дээд сургуулийн тэргүүлэх чиглэлийн байгалийн шинжлэх ухаан, инженер, технологи, хөдөө аж ахуйн бакалаврын хөтөлбөрийн 60 суурь хичээлийн агуулга, 30 сурах бичигт жендэрийн дүн шинжилгээ хийсэн.

Мөн их, дээд сургуулийн удирдлага, багш, ажилтны жендэрийн мэдрэмжийг нэмэгдүүлэх зорилгоор хот, хөдөө орон нутгийн 18 сургуулийн 192 (64.1% эмэгтэй) багш, ажилтны чадавх бэхжүүлэх сургалтыг зохион байгуулсан.

3.2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 7-р зүйлд заасан тусгай арга хэмжээг хэрэгжүүлэх замаар боловсрол (цэцэрлэгийн болон бага ангийн багш), эрүүл мэнд (эмч сувилагч, асрагч)-ийн чиглэлээр суралцах эрэгтэйчүүд, мэдээллийн технологи, инженерийн чиглэлээр суралцах эмэгтэйчүүдийг нэмэгдүүлэх.

БШУЯам нь Дээд боловсролын шинэчлэлийн төсөлтэй хамтран Дээд боловсролын бодлого, эрх зүйн орчны жендэрийн дүн шинжилгээ хийж, үр дүнд тулгуурлан элсэлтийн бодлогыг жендэрийн мэдрэмжтэй болгох, жендэрийг харгалзсан хичээлийн хөтөлбөр, сургалтын арга зүйг дэмжих таатай орчинг бүрдүүлэх, эрдэм шинжилгээнд жендэрийн шударга ёсыг хангах бодлого, зохицуулалтыг төлөвшүүлэх, хөдөлмөрийн харьцаанд жендэрийн шударга ёсыг хангах, ажлын байран дахь бэлгийн дарамтын эсрэг бодлого, зохицуулалтыг нэвтрүүлэх нөлөөллийн ажлыг хийсэн.

Дээд боловсролын салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангахад түлхэц болох нөлөөллийн үйл ажиллагааны хүрээнд шторк, нэвтрүүлэг, баннер, баримтын хуудас, бодлогын хуудсыг боловсруулж, улсын хэмжээнд нийт 21 аймаг, Улаанбаатар хотын ЕБС, ИДС-иудад түгээн, телевиз, сошиал сүлжээгээр цацаж давалгаа үүсгэн, төлбөрт пост хийж 280,903 хүнд хүргэсэн байна.

3.3. Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөр, сурах бичигт жендэрийн болон жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийг үл тэвчих ойлголт, хандлагыг төлөвшүүлэх асуудлыг тусгах.

Монгол Улсын хэмжээнд нийгмийн ажилтан, эрх зүйч, сэтгүүлч бэлтгэдэг нийт 35 их, дээд сургуулийн суурь болон заавал судлах мэргэжлийн хичээлийн хөтөлбөрт жендэр, жендэрийн тэгш бус байдал, жендэрт суурилсан хүчирхийллийн асуудлыг тусган нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий 3 ажлын хэсгийг Хорооны дэргэд байгуулан хамтран ажиллав. Энэ хүрээнд 3 сургалтын модуль, 2 сургалтын хөтөлбөр боловсруулж 35 их дээд сургуулийн 66 багш нарыг тус хөтөлбөрөөр чадавхжуулахын зэрэгцээ нийгмийн ажилтны, сэтгүүл зүйн сургалтын хөтөлбөрт жендэрийн асуудлыг тусгав.

Жендэрт суурилсан хүчирхийллийн асуудлыг АШУҮИС-ийн сургалтын хөтөлбөрт тусгах зорилгоор сургалтын хөтөлбөрт хурдавчилсан үнэлгээ хийж, үнэлгээний дүн, зөвлөмжид үндэслэн эрүүл мэндийн анхан шатны байгууллагын хүний их эмч болон нийгмийн ажилтны ангийн сургалтын хөтөлбөрт гэр бүлийн хүчирхийллийн эсрэг, түүнээс урьдчилан сэргийлэх арга замын талаарх агуулга, цөм хөтөлбөрийг боловсрууллаа.



3.4.Бусдыг хүндлэх, гэр бүлийн болон ойр дотны хүнээ хайрлан хүндлэх, хүнлэг чанарыг эрхэмлэх,эрүүл амьдралын зан үйлд суралцаж, хорт буруу зуршлаас ангижрах, арга ухааны төлөвшүүлэх, чиглэлээр сургалт, сурталчилгааг тасралтгүй явуулах.

ХНХЯ, ГБХЗХГазраас орон нутаг, нийслэл, дүүргүүд тус чиглэлээр тасралтгүй арга хэмжээ зохион байгуулж ирсэн бөгөөд улсын хэмжээнд 2219 удаагийн сургалт, 7376 удаагийн сурталчилгаа, 30354 ширхэг тараах материал, гарын авлагыг олон нийтэд хүргэж ажиллалаа.

“Монголын гэр бүлийн асуудал, хэрэгцээ, үйлчилгээний хувилбар” судалгааны тайлан эмхэтгэл, гарын авлагыг хэвлүүлэн 21 аймаг, нийслэл, 9 дүүрэгт хүргүүллээ.

3.5.Гэр бүлийн үнэ цэнэ, хамтын амьдралын утга учир, эцэг эхийн хамтын үүрэг, хариуцлагыг таниулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ зохион байгуулах, үр хүүхдээ шударга хөдөлмөрч, ёс суртахуунтай хүн болгон хүмүүжүүлж байгаа гэр бүлийг сурталчлах, урамшуулах.

Үр хүүхдээ хөдөлмөрч, шударга, ёс суртахуунтай иргэн болгон төлөвшүүлж байгаа гэр бүлийг сурталчлах, урамшуулах ажлын хүрээнд 228 удаагийн зөвлөгөөн арга хэмжээгээр 81804 иргэн, 10550 хүүхэд, 26307 гэр бүл, 93 удаагийн сургалтаар 12981 иргэн, 5869 хүүхэд, 21301 гэр бүлийг тус тус хамруулж, 551 гэр бүлийг шилдэг гэр бүлээр тодорхойлон олон нийтэд сурталчлан таниуллаа. Дээрх агуулгыг сурталчлах хүрээнд 21 аймаг, нийслэл 9 дүүрэг болон тухайн аймаг дүүргийн ГБХЗХГ-тай хамтран сайн туршлагауд тасралтгүй хэрэгжсээр байна.

3.6.Гэр бүл судлалыг хөгжүүлэх, гэр бүл судлаач, сэтгэл зүйчийг бэлтгэх арга хэмжээг дэмжиж, хүний нөөцийг бэлтгэх.

Улсын хэмжээнд Гэр бүлд зөвлөгөө өгөх 22 төв ажиллаж байна. Гэр бүлд зөвлөгөө өгөх төвийн үйл ажиллагаа тогтмолжсон бөгөөд нийт ажилтнуудын 72.7 хувь нь гэр бүл судлаач, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан ажиллаж байна. Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх зорилгоор мэргэжлийн 4 байгууллагатай хамтран ажиллаж, ажилтнуудыг арга зүйгээр хангах, чадавхижуулах ажлууд тогтмол хийж, албан хаагчдыг гэр бүлтэй ажиллах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх арга зүй сайжирсан.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулан сэтгэцийн 2 эмчийг ажиллуулж, амиа хорлолт, хүчирхийлэл, архи мансуурах зэрэг асуудлаар хүүхэд, залуучууд, гэр бүлийн гишүүдэд үнэ төлбөргүй сэтгэцийн эрүүл мэндийн зөвлөгөө өгөх үйлчилгээг 2019 оны 3 дугаар сараас эхлэн үзүүлж байна.

3.8.Хэвлэл мэдээллийн байгууллагын жендэрийн мэдрэмжтэй байдалд дүн шинжилгээ хийх.

Хороо нь НҮБ-ын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагаас Олон улсын сэтгүүлчдийн холбоо болон бусад түнш байгууллагатай хамтран боловсруулсан “Хэвлэл мэдээлэл дэх жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлт”-д тулгуурласан шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулах, нэтрүүлэх ажлыг Хэвлэл, мэдээллийн зөвлөлтэй хамтран хэрэгжүүлэхээр ажлыг эхлүүлэв.

3.9.Сэтгүүлч бэлтгэх сургалтын хөтөлбөрт жендэрийн асуудлыг тусгаж, сэтгүүлчдийг жендэрийн чиглэлээр үе шаттай сургалтад хамруулах.



Сэтгүүлч бэлтгэх сургалтын хөтөлбөрт жендэрийн асуудлыг тусгах сургалтын модулийг сэтгүүлч бэлтгэдэг их дээд сургуулийн багш нартай хамтран боловсруулж, тус модулиар 15 их дээд сургуулийн 35 багш, сэтгүүлчдийг чадавхжуулаад байна.

МУИС-ын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн 9 хичээлийн агуулга болон оюутны ангийн ажил, дипломын ажлын сэдэвт жендэр, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж, сэтгүүл зүйн ангийн оюутнуудад зориулан “Жендэрийн мэдрэмжтэй сэтгүүлч” сургалтын гарын авлага боловсруулж сэтгүүлч бэлтгэдэг бусад их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт жендэрийн асуудлыг тусгах, сэтгүүлчдийг үе шаттай сургалтад хамруулах ажлуудыг зохион байгуулж байна.

Мөн хэвлэл мэдээллийн зөвлөлийн гишүүд болон бусад холбогдох хэвлэл мэдээллийн байгууллагын удирдлагуудад зориулсан “Хэвлэл мэдээллийн бодлого, төлөвлөлтөд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг нэвтрүүлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

3.10. Жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн шинэлэг дүр төрхийг бий болгох ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан үе шаттайгаар зохион байгуулах.

Хороо, Монголын Хэвлэлийн хүрээлэнтэй хамтран жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэг, ойлголтыг сайжруулах зорилгоор сүүлийн 3 жилд хэрэгжүүлсэн мэдээлэл, харилцааны үйл ажиллагаа болон холбогдох газруудаас цуглуулсан баримт бичигт үнэлгээ хийсэн. Үнэлгээний дүгнэлтийг үндэслэн “Жендэрийн тэгш байдлын талаарх олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх мэдээлэл харилцааны стратеги” боловсруулан орон нутагт туршиж, тус стратегийн хүрээнд төрийн албан хаагч, иргэний нийгмийн төлөөлөл болон иргэдэд эмзэг бүлгийг дэмжсэн, нийгмийн давхаргуудыг тэгш хүртээмжтэй хамруулсан, жендэрийн мэдрэмжтэй орон нутгийн бодлого, үйл ажиллагааг таниулан сурталчлахад дэмжлэг үзүүлэх зорилготой 3 сарын кампанит аян зохион байгууллаа.

3.11. Соёл урлагийн салбарын бодлого, үйл ажиллагаанд жендэрийн хэвшмэл ойлголт, ялгаварлан гадуурхалтыг арилгах жендэрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх.

СУИС-ийн харьяа сургуулиудад заавал үзэх 11 хичээлээс 7 хичээлийн хөтөлбөрт жендэр, жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх ойлголт, мэдлэгийг сайжруулах, жендэрийн хэвшмэл ойлголтыг халах, эрх тэгш байдалд суурилсан хандлагыг төлөвшүүлэх зорилготой агуулгыг тусгаж, сургалтын гарын авлагыг боловсруулаад байна.

3.12. Бүх нийтийн жендэрийн мэдлэгийг дээшлүүлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг хариуцлагыг өндөржүүлж жендэрийн асуудлаар тухайлсан нийтлэл нэвтрүүлэг тогтмол гаргах.

ЖҮХ, Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз (МҮОНРТ) хамтран ажиллах Харилцан ойлголцлын санамж бичиг 2019 онд байгуулав. МҮОНРТ-тэй байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд тус телевизээр 14 хоног тутамд жендэрийн чиглэлийн мэдээ, нэвтрүүлгүүдийг бэлтгэн цацав.

Жендэрийн үндэсний хорооны [www.gender.gov.mn](http://www.gender.gov.mn) цахим мэдээллийн сайтыг монгол, англи хэл дээр ажиллуулж байна. Нийгмийн сүлжээнд



<https://www.facebook.com/gender.gov.mn> facebook хуудсыг идэвхитэй ажиллуулж, олон нийтэд жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой мэдээ, мэдээллийг тогтмол түгээж байна.

3.13.Эрэгтэйчүүд, ялангуяа 18-35 насныханд зориулан жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгах, үндэсний уламжлалт, дэвшилтэт зан үйл, хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, эрэгтэйчүүдийн оролцоог дэмжсэн аян, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд Жендэрт суурилсан хүчирхийллийг таслан зогсоход эрэгтэйчүүд залуучуудыг татан оролцуулах зорилгоор олон нийтийг хамарсан аян, уралдаан, лекц, эрдэм шинжилгээний бага хурал зэргийг жил бүр уламжлал болгон зохион байгуулж байна.

Жендэрийн салбар зөвлөл, Нийслэл, 9 дүүрэг, 21 аймгийн жендэрийн салбар хороо болон хорооны гишүүн байгууллагууд Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аянд 2017 оноос идэвхитэй нэгдэж эхэлсэн.

#### **Зорилт 4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний чадавхыг бэхжүүлэх хүрээнд:**

4.1.Жендэрийн салбар зөвлөл болон хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмын үлгэрчилсэн загварыг баталж мөрдүүлэх.

Жендэрийн үндэсний хороо нь төрийн захиргааны төв байгууллагад яамны төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан жендэрийн салбар зөвлөл, нутгийн захиргааны байгууллагад тухайн шатны засаг даргаар ахлуулсан салбар хороотой бөгөөд 14 яам болон 21 аймаг, нийслэл, нийслэлийн 9 дүүрэгт нийт 45 салбар зөвлөл, хороо ажиллаж байна. Жендэрийн салбар зөвлөл, салбар хороо нь бүрэлдэхүүн болон ажиллах журамдаа гишүүдийн ажил, чиг үүргийг нарийвчлан тусгахаар ажиллаж байна.

4.2.Жендэрийн үндэсний хорооны дэргэдэх Жендэрийн шинжээчдийн бүлэг, Жендэр консорциум, хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих.

ЖҮХ-ны хуралдааны 2018 оны 3, 4 дүгээр тогтоолоор Жендэрийн үндэсний хорооны дэргэд Жендэрийн үндэсний шинжээчдийн бүлэг, Эрдэмтэн, судлаачдын бүлгийг байгуулсан. ЖҮХ-ны Ажлын албаны даргын 2020 оны А/04, А/32 тоот тушаалаар Эрдэмтэн судлаачдын бүлгийн (9 гишүүнтэй), болон Жендэрийн үндэсний шинжээчдийн бүлгийн (28 гишүүнтэй) бүрэлдэхүүн, ажиллах дүрмийг тус тус баталсан.

Ажлын алба нь бүлэг, зөвлөлийн үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллах 45 гэрээ байгуулж, 9 ном хэвлэл хэвлүүлэхэд хамтарж ажилласан байна.

4.3.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтэд үр дагаврын үнэлгээ хийх.

Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг “Эм эм си жи” байгууллагатай хамтран гүйцэтгэлээ. Хуулийн үр дагаврын үнэлгээний үр дүнг УИХ, Засгийн газар болон холбогдох талуудад танилцуулж, үндэсний хэмжээнд хэлэлцүүлэх ажлыг 2021 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.



4.4.Төрийн албан хаагчдын жендэрийн талаарх ойлголт, хандлагыг өөрчлөх, манлайллыг бий болгох чиглэлээр сургалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, үндэсний сургагч багш бэлтгэх.

Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалтын агуулгад жендэр, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт, жендэрийн статистик, хяналт-шинжилгээ, үнэлгээ сэдвүүдийг оруулж батлуулж, Удирдлагын Академи дээр сургалтыг явуулж байна.

ЖҮХ-ны Ажлын албаны дэргэд Сургалт, судалгааны танхим байгуулж, “Жендэр ба бодлого төлөвлөлт”, “Жендэрийн дүн шинжилгээ ба бодлого төлөвлөлт” сургагч багшийн модуль боловсруулж, тус модулиар нийт 105 жендэрийн сургагч багш бэлтгээд байна.

Мөн танхимын болон цахим хэлбэрээр суралцах 8 сургалтын модуль, 5 удирдамж, гарын авлага, 1 сургалтын хөтөлбөр боловсруулсан бөгөөд ОУ-ын бага хурал, үндэсний чуулган, сургалт, семинар зэрэг 674 арга хэмжээ зохион байгуулж 32,445 төрийн албан хаагчдыг чадавхжуулаад байна.

4.6.Удирдах ажилтанд зориулсан жендэрийн цахим сургалтын модуль боловсруулан нэвтрүүлэх.

Төрийн албаны Удирдах ажилтанд зориулсан жендэрийн цахим сургалтын модулийг боловсруулж, ЖҮХ-ны цахим сайт болон Хүний Эрхийн Үндэсний Комиссын цахим сургалтын кампуст байршуулсан. Тус цахим сургалтад нийт 1159 удирдах албан тушаалтан (нийт төрийн албан хаагчдын удирдах ажилтны 48%) хамрагдаж гэрчилгээ аваад байна.

4.7.Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимтай хамтран шилдэг аж ахуйн нэгж шалгаруулах шалгуурт жендэрийн эрх тэгш байдлын үзүүлэлтийг тусгах. МҮХАҮТ-тай хамтран ажиллах, оны шилдэг шилдэг аж ахуй нэгж шалгаруулах шалгуурт жендэрийн үзүүлэлтийг тусгах талаар харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, хамтран ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр 4 үзүүлэлт, түүнийг ашиглах зөвлөмжийг танхимын оны шилдэг ААН шалгаруулах шалгуур үзүүлэлтэд тусгалаа.

4.8.Ажил олгогч, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих хөшүүргийг тодорхойлж сурталчлах.

“Хувийн хэвшлийн байгууллагуудад жендэрийн тэгш байдлыг хангах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх зөвлөмж”-ийг боловсруулан хэвлүүлж төр, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагуудад хүргүүлэв.

4.9.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр үр дүнтэй ажилласан аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдийн үйл ажиллагааг сурталчлах, туршлагыг түгээн дэлгэрүүлэн урамшуулах.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр орон нутагт хэрэгжиж буй сайн туршлагыг дэмжин ажиллах хүрээнд 6 аймгийн сайн туршлагыг сайжруулан хэлэлцүүлэх Хорооны тогтоолыг батлуулж, түгээн дэлгэрүүлэх ажлыг үндэсний хэмжээнд хүргэхээр ажиллаж байна. Жендэрийн чиглэлээр үр дүнтэй ажилласан 8 байгууллага, 16 албан хаагчийг мөнгөн урамшууллаар шагнаад байна.

Тухайлбал, Архангай аймгийн Онцгой байдлын газрын “Жендэрийн мэдрэмжтэй байгууллагын соёлыг төлөвшүүлсэн үйл ажиллагаа”, Баянхонгор аймгийн “Орон нутгийн ТББ-уудад зориулсан жендэрт суурилсан хүчирхийлийн хохирогчдод цогц



үйлчилгээний арга зүйг түгээн дэлгэрүүлэх хамтын ажиллагаа”, Орхон аймгийн “Эрэгтэйчүүдийн кабинет байгуулах үйл ажиллагаа”, Сэлэнгэ аймгийн “Сэлэнгэ аймгийн эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд-2018 жендэрийн статистикийн блютень”, Увс аймгийн “Малчин өрхийн хүүхдэд бага боловсрол олгох бодлогын хэрэгжилтийг жендэрийн арга зүйгээр дэмжих үйл ажиллагаа” зэрэг болно. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд манлайлан ажилласан УУХҮЯ, БХЯ, БХБЯ-ны салбар зөвлөл, Нийслэл, Баянхонгор, Дорнод, Өвөрхангай аймгийн салбар хороо болон УУХҮЯ, ГХЯ, ХХААХҮЯ, БХЯ, ХНХЯ, ХУД-ийн жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэнүүдийг тус тус шалгаруулав.

4.10. Аймаг, нийслэл, дүүргийн жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиглэлээр орон нутаг дахь төрийн бус байгууллагын чадавхыг нэмэгдүүлэх.

Орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрт оролцооны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлалыг боловсруулж, 21 аймгийн төрийн бус байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах бүсийн сургалтуудыг зохион байгуулав.

#### **Зорилт 5. Хүчирхийлэл болон ялгаварлан гадуурхалттай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд:**

5.1. Хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллах заавар боловсруулан Хүний эрхийн үндэсний комисс болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн орон нутгийн салбар зөвлөл, холбогдох ажилтанд хүргүүлж, сургалтад хамруулав.

Хохирогчийг хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төвд ажиллаж буй нийгмийн ажилтан болон холбогдох төрийн албан хаагчдад зориулсан жендэрт суурилсан хүчирхийллийн тохиолдолд хариу арга хэмжээ авах чиглэлээр сургалтын хөтөлбөр боловсруулан, үе шаттай сургалтуудыг зохион байгуулж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20 дугаар зүйлд сум, хорооны Засаг даргаар ахлуулсан Хамтарсан багт өрхийн эмч, сум, хороо, сургуулийн, халамжийн, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн нийгмийн ажилтан, цагдаагийн алба хаагч, энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэн ажилладаг 676 хамтарсан багийн 4714 гишүүнийг сургасан.

Мөн “Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тэмцэхэд хууль зүйн салбарын чадавх, уялдаа холбоог бэхжүүлэх сургалт”-ыг удирдан заах 60 сургагч багш бэлтгэн, 21 аймаг, нийслэлийн цагдаа, прокурор, шүүгч, өмгөөлөгч зэрэг 900 гаруй хүнийг хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэргэшүүлэх хамтарсан сургалтад хамруулсан.

5.2. Охид, эмэгтэйчүүдийг хүний наймаа, бэлгийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлэх.

“Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх” үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолоор баталсан. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, Хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын алба хаагчдын хүн худалдаалах гэмт хэргийн талаарх ойлголт, мэдлэг, туршлага, чадавхийг үнэлэх судалгаа хийхийн зэрэгцээ цагдаа болон прокурор, хил хамгаалах, гадаадын иргэн харьяатын байгууллагын алба хаагч, шүүгч, өмгөөлөгч, нийгмийн ажилтан, эрүүл мэндийн ажилтан нарыг мэргэшүүлэх,



мэргэжил, ур чадварыг нэмэгдүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг улсын хэмжээнд тасралтгүй зохион байгуулж байна.

Нөлөөллийн ажлын үр дүнд хүн худалдаалах гэмт хэргийн талаарх иргэдийн ойлголт, мэдлэг нэмэгдэж өөрсдийгөө энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн эсэх үнэлгээ, нөгөө талаас төрийн албан хаагч, үйлчилгээ үзүүлэгч нарыг гадаад болон дотооддоо илрүүлэх ур чадвар нэмэгдэж, хохирогчид үзүүлэх үйлчилгээг сайжруулсны үр дүнд 2018 онд нийт 19 иргэн, 2019 онд 7 иргэнийг тус тус гадаад улсаас эх оронд нь аюулгүй буцаан авчрах ажлыг олон улсын байгууллгын дэмжлэгтэйгээр зохион байгууллаа.

5.3. Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээх.

Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх зорилгоор 2017 онд Хайрла-Хамгаал, 2018 онд ОйлГоё-Хүндэлье, 2019 онд Эерэг бол Гоё, 2020 онд Яг одоо цэглээ соён гэгээрүүлэх нэгдсэн арга хэмжээг тус тус зохион байгуулав.

Мөн Ковид-19 цар тахлын улмаас тогтоосон хөл хорионы улмаас гэр бүлийн хүчирхийллийн зөрчил нэмэгдэх хандлага байдаг тул 2020 оны 4 сард Хайр-Өвтгөдөггүй нэгдсэн арга хэмжээг зохион байгуулав.

5.4. Аж ахуйн нэгж, байгууллагад хүчирхийлэл, түүний дотор ажлын байр дахь бэлгийн дарамт гарахаас сэргийлэх, хохирогчийн хүсэлт, гомдлыг ажил олгогчийн зүгээс шийдвэрлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд иргэнийг ажилд авах болон хөдөлмөрийн харилцаа үүсэхээс дуусгавар болгох үе шатанд хүйс, эрүүл мэндийн байдал, жирэмсэн эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, гадаад төрх зэрэг нөхцөлөөр бодит болон бодит бус мэдээлэлд үндэслэн шууд болон шууд бусаар ялгаварлах, эсхүл хязгаарлах, давуу байдал тогтоохыг хориглосон зохицуулалтыг тусгасан.

5.5. Хүчирхийлэлд өртсөн хохирогчийг хамгаалах нэгж (Нэг цэгийн үйлчилгээний төв, Хамгаалах байр зэрэг)-ийг бүх аймагт ажиллуулж, үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх.

Гэр бүлийн хүчирхийллээс хүүхэд, эмэгтэйчүүдийг хамгаалах, шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлэх зорилгоор НҮБ-ын Хүн амын сантай хамтран хэрэгжүүлсэн “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь” төслийн санхүүгийн дэмжлэгээр нийслэлийн Чингэлтэй дүүрэгт 8, Сүхбаатар дүүрэгт 20 үйлчлүүлэгч хүлээн авах хүчин чадалтай Нэг цэгийн үйлчилгээний төвийг 2020 оны 6 дугаар сард шинээр байгуулаад байна.

Одоо улсын хэмжээнд 18 Нэг цэгийн үйлчилгээний төв, 15 Түр хамгаалах байр хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах чиг үүрэгтэй ажиллаж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, холбон зуучлах ажлыг зохион байгуулах тухай” журмыг ХНХ-ын сайдын 2020 оны А/149 тушаалаар, “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардал тооцох журам”-ыг 2020 оны ХНХ-ын сайдын А/150 дугаар тушаалаар тус тус батлан мөрдөж эхэллээ.



Монгол Улсын Засгийн газар нь хуулийн хэрэгжилтийг хангаж гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид тусламж, үйлчилгээ үзүүлдэг нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулахад 2016-2020 онд нийт улсын хэмжээнд төсвөөс 1 тэрбум 83 сая төгрөг, үйл ажиллагаа, хохирогч хамгааллын үйлчилгээ, орон тоо, цалинд нийт 1 тэрбум 183 сая төгрөгийг тус тус санхүүжүүлсэн.

#### **Зорилт 6. Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх хүрээнд:**

6.1. Улс төрийн болон төрийн захиргааны удирдах албан тушаалд эмэгтэй, эрэгтэй хүнийг санал болгох, нэр дэвшүүлэх, өрсөлдүүлэх шалгуурыг тогтоож, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан квотыг хэрэгжүүлэх.

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт нэр дэвшигчдийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийн төлөөлөл байхаар хуульчилсан бөгөөд ХЭҮК-ын тухай хуулийн шинэчилсэн найрууллагын төсөлд нийт 5 гишүүний 40 хувь нь аль нэг хүйсийн гишүүн байхаар тусгагдсан. Түүнчлэн орон нутгийн сонгуулийн тухай хуулийг 2020 онд шинэчлэн баталж, анх удаа аль нэг хүйсийн төлөөлөл 20-иос доошгүй байхаар заасан нь эмэгтэйчүүдийг хамгийн багадаа 20 хувь түүнээс дээш нэр дэвшүүлэх эрх зүйн орчинг бүрдүүллээ.

2016 оны УИХ-ын сонгуульд түүхэндээ анх удаа хамгийн олон буюу 13 эмэгтэй гишүүн сонгогдсон бөгөөд энэхүү амжилтыг 2020 оны сонгуульд ахиулж чадаагүй боловч бататган хадгалж чадлаа. 2016-2020 оны орон нутгийн сонгуульд эмэгтэйчүүд 23-24 орчим хувиар сонгогдон ажиллаж байгаа нь төрийн удирдлагын анхан шатанд эмэгтэйчүүд манлайлах, нэмэгдэх хандлагатай байна.

Улс төрийн болон төрийн захиргааны удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийн эзлэх хувийг харвал: УИХ- 17%, Засгийн газрын гишүүд- 18%, Дэд сайд-15%, Яамдын Төрийн нарийн бичгийн дарга-9%, Засгийн газрын агентлагийн дарга- 12%, Яамдын газар, хэлтэс, албадын дарга эрхэлсэн түшмэл-35%, Засаг дарга нар аймаг- 38,4%, дүүрэг- 47%, сумд- 42,3%, хороод- 71,4% байна.

6.2. Эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах түвшинд ажиллахад бэлтгэх, чадавхжуулах, манлайллыг бий болгох чиглэлээр эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагатай хамтран ажиллах.

Эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшин дэх оролцоог нэмэгдүүлэхэд тулгарч буй саад бэрхшээлийг тодорхойлох, холбогдох эрх зүйн орчныг сайжруулах, шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа эмэгтэйчүүдээ тогтвортойгоор дэмжин ажиллах чиглэлээр УИХ-ын гишүүд, намуудын дэргэдэх эмэгтэйчүүдийн байгууллагууд хамтран зөвшилцөх уулзалтуудыг зохион байгуулав.

УИХ-ын 2020 оны ээлжит сонгуулийн үеэр “Тэнцвэртэй хүч” аянг зохион байгуулав. 15 нам 4 эвсэлд уриалга хүргүүлж Улс төр шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор олон нийтэд зөв уриалгыг хүргүүлэх хэвлэл мэдээллийн 1 сарын аян зохион байгуулж видео, шторк мэдээллийг хүргэж ажиллаа. Энэ хүрээнд 28 ТББ-тай хамтран ажилласан байна.

6.3. Нутгийн өөрөө удирдах байгууллагын бодлого, үйл ажиллагаанд жендэрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх арга хэмжээ авах.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын бодлого, үйл ажиллагаанд жендэрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх уриалга, түүнийг хэрэгжүүлэх удирдамжийг гарган Үндэсний Семинар зохион байгуулж 124 төлөөлөгчийг хамрууллаа.



Орон нутаг нийслэлд нутгийн өөрөө удирдах байгууллагын 403 төлөөллийг жендэрийн чиглэлээрх сургалтуудад хамруулсан байна.

**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (2015 он)	Өнөөгийн түвшин (2020 он)	Зорилтот түвшин (2021 он)
1.	Хөдөлмөрийн мөлжлөг, ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх асуудлыг дотоод журамдаа тусгасан байгууллага, аж ахуйн нэгжийн тоо	хувь	-	<b>0,3 хувь</b>	35 хувь
2.	Эрэгтэйчүүдэд тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн тасаг, кабинет	тоо	11	<b>35</b>	35
3.	Монгол Улсын жендэрийн нөхцөл байдалд хийсэн үнэлгээ	тоо	-	<b>1</b>	1
4.	Яамд (салбар)-ын жендэрийн нэгдсэн бодлого, аймаг, дүүргийн жендэрийн дэд хөтөлбөрийн тоо	тоо	Яам-3 аймаг-3	<b>Яам-9, аймаг, дүүрэг-30</b>	бүх яам аймаг, дүүрэг- 30
5.	Оролцоонд суурилсан жендэрийн үнэлгээ хийсэн яам (салбар), аймаг, дүүрэг	тоо	яам-3 аймаг, дүүрэг-0	<b>яам-10 аймаг, дүүрэг-28</b>	бүх яам аймаг, дүүрэг-30
6.	Боловсрол, эрүүл мэндийн чиглэлээр их, дээд сургуульд суралцагчдын дунд эрэгтэйчүүдийн эзлэх хувь	хувь	18 хувь	<b>18 хувь</b>	50 хувь
7.	Мэдээллийн технологи, инженерийн чиглэлээр их, дээд сургуульд суралцагчдын дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь	хувь	30 хувь	<b>30 хувь</b>	50 хувь
8.	Жендэрийн мэдрэмжтэй байдлын үнэлгээ хийгдсэн хэвлэл мэдээллийн байгууллага	тоо	2	<b>2</b>	20
9.	Жендэрийн үндэсний сургагч багшийн тоо	тоо	90	<b>104</b>	180
10.	Жендэрийн сургалтад хамрагдсан удирдах ажилтан (УА), төрийн албан хаагч (ТАХ)	хувь	УА-15 ТАХ-25	<b>УА-48 ТАХ-60</b>	УА-65 ТАХ-75
11.	жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд орон нутаг дахь ТББ-аас хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тоо	тоо	-	<b>15</b>	30
12.	Аймаг, нийслэл, дүүрэгт ажиллаж байгаа хохирогчийг хамгаалах нэгжийн тоо	тоо	10	<b>НЦҮТ-18 ХБ-15 Нийт 32</b>	30

-oOo-